



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬАА

**БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Энхтайвны өргөн чөлөө 10, Багшийн хөгжлийн ордон,
Утас, факс: (976) 7014 0069, <http://www.itpd.mn>

2018.10.05 № 1/355

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗАР, АЙМГУУДЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАРТ

Мэргэжил дээшлүүлэх үндсэн
сургалтын онлайн бүртгэлийг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль” батлагдаж 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээр болсон билээ.

Боловсрол, шинжлэх ухаан сайдын 2013 оны А/287 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд энэ хичээлийн жилийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын бүртгэлийн тухай мэдээллийг харьяа ЕБС, цэцэрлэгийн багш, удирдах ажилтанд хүргэж, бүртгэл зохион байгуулахыг үүгээр мэдэгдэж байна.

Сургалтын бүртгэл 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал явагдах ба <http://burtgel.itpd.mn/> цахим хуудсаар хандаж зааврын дагуу бүртгүүлнэ.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 9.4 дахь зүйлд зааснаар энэ хичээлийн жилд багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 2009, 2014, 2018 онуудад багш мэргэжлээр төгссөн иргэдийг бүртгэлд хамруулна.

Дээр дурдсан онд багш мэргэжлээр төгссөн боловч сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад ажиллахгүй байгаа багш мэргэжилтэй иргэд сургалтад үнэ төлбөргүй хамрагдах эрхтэй бөгөөд томилолт, унааны зардал олгохгүй.


Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтан, бусад ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтад тухайн албан тушаалд 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй ажилтныг хамруулна.

Онлайн бүртгэлд үндэслэн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын төсөв, төлөвлөгөө, хуваарь хийгдэх тул багш мэргэжлээр төгссөн, сургалтын байгууллагад ажиллаж буй багш, ажилтанд мэдээллийг түргэн шуурхай хүргэж, өгөгдсөн хугацаанд бүртгэлд бүрэн хамруулахыг зөвлөж байна.

Оролцогчдыг онлайн бүртгэлээс хоцорсон тохиолдолд сургалтад хамруулах зардлыг төсвөөс олгох боломжгүй бөгөөд сургалтын зардлыг оролцогч өөрөө хариуцах болохыг мэдэгдье.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮРЭНЧИМЭГ



2018 689